



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

11.4. Байнгын хорооноос санал болгох нэр дэвшигч хувийн хэвшлийг төлөөлсөн байж болно.

11.5. Хорооны гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

11.5.1. төрийн улс төрийн албан хаагч;

11.5.2. улс төрийн намын удирдах албан тушаалтан;

11.5.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч прокурор;

11.5.4. санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдэд ажиллаж байгаа этгээд;

11.5.5. санхүүгийн үйлчилгээ явуулж байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч.

11.6. Хорооны дарга, гишүүн нь эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Булган Ургийн овог: Ганжуур Нэр: Саруул Хүйс: Эм Төрсөн он: 1980 Төрсөн газар: Улаанбаатар Иргэний харьяалал: Монгол Улс Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: Хан-Уул дүүрэг, 18-р хороо /мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
-----	---

1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮН
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/</i> Тийм
1.4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. <i>/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/</i> - Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Бизнесийн удирдлагын магистр, Магистрын зэрэг хамгаалсан сэдэв – <i>Монголын компаниуд Хонконгийн хөрөнгийн бирж дээр хадгаламжийн бичиг гаргах боломжийг тодорхойлох судалгаа</i> (2018). - МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургууль, Олон улсын харилцааны бакалавр (2002)..
1.5	Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг
1.6	Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана. - СЭМҮТ-ийн тодорхойлолт хавсаргав
1.7	Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр эзэмшсэн мэргэжлээрээ таваас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч <i>/эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</i> - Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ерөнхийлөгч Л.Төр-Од, утас: 99191007, хаяг: Махатма Гандигийн гудамж, ХУД, 15-р хороо, www.mongolchamber.mn , Ерөнхий нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (12.2024-с) - Хөдөө аж ахуйн бирж ХХК, хаяг: БЗД, 1-р хороо, НАМАС оффис, 208 тоот, утас: 70128779, www.mse.mn , Захиргаа, санхүүгийн хэлтсийн менежер, (06.2022-10.2024) - Хөдөө аж ахуйн бирж ХХК, хаяг: БЗД, 1-р хороо, НАМАС оффис, 208 тоот, утас: 70128779, www.mse.mn , Дэд захирал, (09.2021-06.2022) - Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, хаяг: Махатма Гандигийн гудамж, ХУД, 15-р хороо, утас: 77277070, www.mongolchamber.mn , Ерөнхий нарийн бичгийн дарга (03.2019-04.2020)

	<p>- Төрийн банк, хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1, утас: 1800-1881, www.statebank.mn, Гүйцэтгэх захирлын орон тооны зөвлөх (12.2016-12.2018)</p> <p>- Хонконгийн Үнэт цаас, фючерсийн хороо, хаяг: 54/F, One Island East, 18 Westlands Road, Quarry Bay, Hong Kong, утас: (852) 2231 1222, enquiry@sfc.hk, www.sfc.hk, Санхүүгийн газар, ахлах менежер, (06.2014-06.2015)</p> <p>- Санхүүгийн зохицуулах хороо, хаяг: Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, утас: 51-264444, www.frc.mn, Үнэт цаасны газрын дарга (10.2011-05.2014)</p> <p>- “Арта-Инвест” ХХК брокер, дилерийн компани, хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүл гудамж 6/2, Од плаза, 406 тоот, Гүйцэтгэх захирал (10.2010-10.2011)</p> <p>- НҮБХХ төсөл, Бодлого зохицуулалт, Засгийн газрын хамтын ажиллагаа хариуцсан ажилтан (03.2008-10.2010)</p> <p>- “Олон улсын хөгжлийн хүрээлэн” ХХК, Австралийн зөвлөх компанийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Гүйцэтгэх захирал (06.2006-02.2008)</p> <p>- НҮБХХ төсөл, Бодлогын асуудал хариуцсан үндэсний зөвлөх (02.2005-06.2006)</p> <p>- Хүүхдийг ивээх сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Үндэсний зөвлөх (10.2002-08.2004)</p>
1.8	<p>Ашиг сонирхлын зөрчил</p> <p>Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <p>- Тийм, Эрдэнэс тавантолгой ХК 1072 ш энгийн хувьцаа.</p>
1.9	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</p> <p>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p>
1.10	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйтцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <p>- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ерөнхий нарийн бичгийн дарга (03.2019-04.2020).</p> <p>- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ерөнхий нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (12.2024-с)</p>
1.11	<p>Мэргэжлийн ёс зүйн талаар</p> <p>Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх. <i>/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>Үгүй</p>

1.12	<p>Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл <u>бэлдэхэд оролцсон</u> аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013.05.24, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2013 он, №24) (https://legalinfo.mn/mn/detail?lawId=9243) - Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль (2013.10.03, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2013 он, №41) (https://legalinfo.mn/mn/detail?lawId=9493) <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p><i>/Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/</i></p>
------	---

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>/500-1000 үгэнд багтаана/.</i></p> <p><u>Үндэслэл</u></p> <p>Миний бие СЗХ-ны Үнэт цаасны газрын даргаар 2011 оны 10 дугаар сараас 2014 оны 05 дугаар сар хүртэл ажиллаж байсан бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, дагалдах журмуудыг боловсруулах ажилд гар бие оролцсон туршлагатай. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас (IOSCO) хөгжиж буй улсуудын зохицуулагчдыг хөгжингүй улсуудын зохицуулагч байгууллагад ажлын байран дээр дадлагажуулах, сургах хөтөлбөрт хамрагдаж, Санхүүгийн зохицуулах хороог төлөөлж Хонконгийн үнэт цаас, фючерсийн хороонд Үнэт цаас гаргах үйл ажиллагааг хариуцдаг Санхүүгийн газарт Ахлах менежерээр 2014 оны 06 дугаар сараас 2015 оны 06 дугаар сар хүртэл ажилласан. Энэ хугацаанд Хонконгийн бирж дээр үнэт цаас гаргах ажиллагааг хянан шийдвэрлэх, Хонконгийн хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд аудит хийх, тус хорооны Хяналт шалгалтын газрын шалгалтын багт орж ажиллаж туршлага хуримтлуулсан. Улмаар Монголын компаниуд Хонконгийн хөрөнгийн бирж дээр хэрхэн хадгаламжийн бичиг гаргах талаар судалгааны ажлыг хийж, 2018 онд СЭЗИС-д Бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Иймд дээр дурдсан өөрийн ажлын туршлага, боловсрол,</p>
-----	--

мэдлэгийг цаашид хөрөнгийн зах зээлийг Монгол Улсад үр дүнтэй, хүртээмжтэй хөгжүүлэхэд зориулан ажиллах чин хүсэлтэй байгааг хүлээн авна уу.

Хийх ажил

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл хурдацтай өсөн тэлж ДНБ-д эзлэх хувь нэмэгдэж байна. Цаашид манай улсын хөрөнгийн зах зээл эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, компаниуд нээлттэй болж, хямд өртөгтэй хөрөнгө оруулалт татан өөрийн үйлдвэрлэлийг тэлэх, ажлын байр бий болгох боломж нөөц байна. Үүнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байна. Үүнд:

- Олон нийтээс хөрөнгө татах компани сайн засаглалтай, тунгалаг байх.
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг бүрэн хамгаалах, ингэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.2-д, 61.1.16-д заасны дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс Хороо хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно гэж заасан байдаг ч хэрэгжүүлж байгаагүй. Тухайлбал Хонконгд зохицуулагч байгууллага жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж шүүхэд хандах тохиолдол түгээмэл бөгөөд хэрэг шийдвэрлэх үйл явц мөн богино хугацаанд шийдэгддэг. Энэхүү арга хэмжээгээр дамжуулан тус салбарт олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт татан үнэт цаасны маргаан шийдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагын чадавхыг бэхжүүлэх, цаашид өмчлөх эрхийн зөрчлөөс сэргийлэх боломжтой.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хадгаламжийн бичиг гадаад зах зээлд гаргах ажлыг дэмжих (одоогоор энэ ажил хийгдээгүй байна.)
- Хөдөө аж ахуйн биржийн ажиллагаа, төлбөр тооцоог олон улсын жишигт хүргэх, улмаар мах, буудай, хүнсний ногооны нийлүүлэлтэд фючерс гэрээг нэвтрүүлэх, ноос, ноолуурын арилжаанд фючерс, агуулахыг бичиг (warehouse receipts) зэрэг санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх.
- Миллениум Ай Ти програм нь хил дамнан үнэт цаас арилжаалах, төрийн өмчит компаниуд Монголын зах зээлд гарахад гадаадын хөрөнгө оруулагчид, тухайлан институциональ хөрөнгө оруулагчид саадгүй манай зах зээлд оролцох боломжийг бүрдүүлэх програм хангамж гэж анхлан танилцуулж нэвтрүүлж байсан. Иймд гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой дотоодын томоохон компани нээлттэй болох эрх зүйн, техникийн бололцоог бүрдүүлэх, дээрх програм хангамжийг бүрэн хүчин чадлаар ашиглах.
- Тэтгэврийн реформыг үргэлжлүүлэх, институциональ хөрөнгө оруулагчдыг бэхжүүлэх зэрэг үнэт цаас төдийгүй, хөдөө аж ахуйн бирж, даатгал зэрэг салбарын хөгжлийг цогцоор нь дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.